

Төсөл



**АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН МОНГОЛ АРДЫН  
НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Уриа:

хүч нэмье





191

## Бор-Өндөр сумын Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөр

### БОР-ӨНДӨР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

/2021-2024 ОН/

/8 бүлэг, 73 зүйл/

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 4.1.1 ДЭХ ЗААЛТ: "аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл" гэж Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хүрээнд тухайн жилд дэвшүүлсэн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон баримт бичгийг" гэсэн заалт болон тус хуулийн 4.1.4, 4.1.5 дахь заалтыг үндэслэн боловсруулсан болно.

#### Эрхэм зорилго:

Монгол Улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд сум орон нутгийн иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөг дээдлэн хангаж ажилладаг төрийн албыг бүрдүүлж, шийдвэр гаргах түвшинд ард иргэдийн оролцоог нэмэгдүүлж, нутаг орноо хэрхэн хөгжүүлэх талаар иргэн бүр ухамсарлаж, асуудалд бодитой ханддаг тохилог, амар тайван, эрүүл сум болгох зорилго тавьсан болно.

Сумын Засаг дарга болон төрийн байгууллага, албан тушаалтны зүгээс хөтөлбөрийн хүрээнд дараах зарчмыг баримтлан ажиллана:

1. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасан иргэний үндсэн үүрэг эрх чөлөөг эдлүүлнэ.
2. Нутгийн өөрөө удирдах байгууллага, сумын ИТХ-аас иргэдийн ашиг сонирхол, эрх ашгийг хамгаалах чиглэлээр ирүүлсэн үүрэг даалгаврыг цаг тухайд нь хэрэгжүүлдэг байна.
3. Төрийн байгууллагын үйл ажиллагааг оновчтой зөв төлөвлөж, хэрэгжүүлнэ.
4. Иргэдийн ухамсар сэтгэлгээнд өөрчлөлт гаргах, хотын болон хамтран амьдрах соёлыг төлөвшүүлнэ.
5. Төрийн байгууллага, албан тушаалтны зүгээс аливаа хэрэгжүүлэх арга хэмжээнд манлайлан оролцдог байна.

#### НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1. Өрхийн эмнэлгийг хэвийн ажиллах нөхцөл бололцоогоор бүрэн хангана. Сумын түвшинд жирэмсэн эхчүүдийн эрүүл мэндийг хамгаалан, үзлэг шинжилгээнд тогтмол хамруулна.

2. Эх, хүүхдийн өвчлөлийг бууруулан, 0-1 насны хүүхдийн эндэгдэлгүй сум болно.

3. Нэгдсэн эмнэлэг болон өрхийн эмнэлгийн эмч сувилагчдыг мэргэшүүлэх, дадлагажуулах ажлыг шат дараатай зохион байгуулна.

4. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, өсвөр насны эмэгтэйчүүдийн хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт, бэлгийн замын халдварт өвчлөлийг бууруулж, мэдлэгтэй эрүүл саруул залуу үеийг төлөвшүүлнэ.

23171442  
СХДА0046 99



## Бор-Өндөр сумын Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөр

5. Хүн амд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, буруу зуршлаас урьдчилан сэргийлэх, зан үйлийг өөрчлөх зорилтот арга хэмжээг хэрэгжүүлнэ. Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг дэмжих, эрчимжүүлэх ажлыг зохион байгуулан нэн түрүүнд тулгамдаж буй нийгмийн эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх тусгай хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

6. Урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогооны чанар, хүртээмжийг сайжруулж, тодорхой төрлийн шинжилгээ, үзлэг оношлогоог хийдэг болох, сургалт, зөвөлгөө тогтмол зохион байгуулна.

7. Ахмад настнуудыг эрүүл мэндийн үзлэг оношлогоонд бүрэн хамруулах, зөвлөгөө мэдээлэл өгөх, амралт сувилалд хэвтэн эмчлүүлэх зэрэг боломжит бүхий л тусламж дэмжлэгийг үзүүлнэ.

8. Эрүүл мэндийн салбарын эмч, ажилтан албан хаагчдын санал санаачлагыг бүрэн дэмжиж урамшуулж ажиллана. Эрүүл мэндийн салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулахад хувийн хэвшлийн мэргэжлийн байгууллагын оролцоог дэмжиж хяналт тавина.

9. Нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэх

10. Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулж, хууль, тогтоомжийн дагуу хяналт, шалгалтыг иргэдийн оролцоотой зохион байгуулж ажиллана.

### ХОЁР. БОЛОВСРОЛ

1. Цэцэрлэгийн насны хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулна. Гэр цэцэрлэг, ээлжийн бүлэг, хүүхэд харах үйлчилгээ зэрэг боломжит бүхий л хувилбарт сургалтыг ашиглан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүрэлцээ, хангамжийг сайжруулж, цэцэрлэгийн насны хүүхдийг 100% цэцэрлэгт хамруулсан байна. Тус суманд үйл ажиллагаа явуулах яслийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.

2. Хүүхдүүдийг ая тухтай байлгах, сайн хүн болон төлөвших чанартай сургалт бүхий цэцэрлэгийн орчныг бүрдүүлж өгнө. Цэцэрлэгийн насны хүүхдүүдийн хөгжлийн үзүүлэлтийн болон цэцэрлэгийн орчны үнэлгээг цэцэрлэг тус бүрээр хийж, үнэлгээний үр дүнд үндэслэн, сургуулийн өмнөх боловсролын чанар, орчныг сайжруулах ажлын хүрээнд цэцэрлэгүүдийг засварлах, сургалтын орчин, анги танхимыг тохижуулах, бага насны хүүхдийн хөгжлийн үзүүлэлтийг бүрэн хангахуйцаар сургалтын чанарыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

3. Сурагчдын сургах орчин нөхцлийг сайжруулах, зорилтод өрхийн хүүхдийн оюутны төлбөрийг хөнгөлөх зэрэгт нийгмийн хариуцлагын хүрээнд томоохон уул уурхайн компаниудын оролцоог нэмэгдүүлэх

Handwritten notes and stamps on the right margin, including a vertical stamp with the number 74082.



## Бор-Өндөр сумын Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөр

4. Багш нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, хүүхэд бүрийг тань бүс нутаг, улс, олон улсын түвшинд өрсөлдөхүйц чанартай боловсрол эзэмших боломжийг олгох, хүүхэд бүрийн авьяас чадварыг илрүүлж хөгжүүлэх, секц дугуйланд хамруулах, багш нарыг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5. Элсэлтийн ерөнхий шалгалтанд өндөр оноо авсан, авьяас чадвартай, сум орон нутагт нэн шаардлагатай байгаа мэргэжлээр суралцахаар болсон болон суралцаж буй, сумандаа эргэж ирж ажиллаж амьдрах хүсэлтэй оюутнуудыг олон улсын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулна.

6. Насан туршийн боловсролын үйлчилгээг хэрэгжүүлнэ. Иргэд нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн, өрсөлдөх чадвартай боловсролыг насан туршдаа тасралтгүй эзэмшдэг байх, гэр бүлийн, иргэний, ёс суртахуун төлөвшлийн, амьдрах ухааны боловсрол олгох үйл ажиллагааг өргөжүүлж, хүн бүрт хүртээмжтэй болгоно.

7. Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөр, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд МСҮТ-ийн сургалтын чанар үр ашгийг дээшлүүлэх зорилгоор сургалтын тоног төхөөрөмжийг сайжруулах, төсөл хөтөлбөрт хамруулна.

8. МСҮТ-өөс эзэмшүүлж буй мэргэжлийг сурталчилж, Ерөнхий боловсролын сургуулийн 9-р анги төгссөн сурагчдын хүсэл сонирхолыг харгалзан, МСҮТ-д элсүүлэх зорилгоор Засаг даргын зүгээс МСҮТ-н захиралтай гэрээ хийж ажиллана.

9. Багийн засаг дарга нараас сургууль завсардсан, иргэдийн судалгаа жил бүр авч тэдгээр иргэдийг МСҮТ-д элсүүлэн суралцуулж мэргэжлийн үнэмлэхтэй ажилтан бэлтгэнэ.

10. Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн МСҮТ-тэй хамтран МСҮТ-ийн төгсөгч нарыг ажлын байранд зуучлах, ажлын байраар хангах ажлыг зохион байгуулна.

### ГУРАВ. НИЙГМИЙН ХАЛАМЖ

1. Нийгмийн халамж үйлчилгээ шаардлагатай зорилтот бүлгүүдэд халамжийн үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд чанартай, хүртээмжтэй хүргэнэ.

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, мөн 40-өөс дээш насны иргэдийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлнэ.

3. Нийгмийн халамж шаардлагатай иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ. Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор нийгмийн халамжийн байгууллагаас үзүүлэх

Handwritten notes and stamps in red ink on the right margin, including the word 'СНО'.



## Бор-Өндөр сумын Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөр

тусгайлсан үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хэрэгжүүлэх мөн сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх санал санаачлагуудыг дэмжиж ажиллана.

4. Ахмад настнуудад зориулсан урлаг соёл, нийгмийн арга хэмжээг тогтмолжуулж, ахмадын танхимын үйл ажиллагааг жигдрүүлнэ.

5. Ахмадуудын санал санаачлагад үндэслэн тэднийг нийгмийн ажилд оролцуулах, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг үзүүлэх, ерөнхий боловсролын сургуульд түүх соёлын асуудлаар лекц унших зэрэг сайн дурын үндсэн дээр тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.

6. Архидан согтуурах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр жил бүр 1-2 аяныг олон нийт, иргэний нийгмийн байгууллага, төрийн байгууллагын санаачлага оролцоон дээр тулгуурлан хэрэгжүүлж, үр дүнг бодитой, ил тод нээлттэй байдлаар олон нийтэд танилцуулж, тодорхой ахиц дэвшлийг гаргасан байна.

7. Жил бүр нийгмийн тодорхой нэг асуудлыг бодит судалгааны үндсэн дээр тодорхойлон, түүнд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Иргэний нийгмийн байгууллагын оролцоо дэмжлэгтэйгээр нийгмийн тодорхой нэг асуудлыг жил бүр сонгон авч олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтийн анхаарлыг хандуулах, тэдэнд эерэг хандлага мэдлэгийг бий болгох нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

### ДӨРӨВ. ТӨРИЙН АЛБА

1. Төрийн албан хаагч бүр бодитой судалгаа мэдээлэлд үндэслэн, орон нутгийн салбарын нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт хийдэг, төсөл хөтөлбөрийн санал боловсруулж дэмжлэг авч, хэрэгжүүлэх бүхий л бололцоог эрэлхийлдэг мэдлэгтэй, чадварлаг, хариуцлагатай боловсон хүчнээр төрийн албыг бүрдүүлнэ.

2. Багийн засаг дарга, багийн зохион байгуулагч нар айл өрхийнхөө амьдралтай танилцаж, тулгамдаж буй асуудлыг шуурхай шийдвэрлэнэ.

3. Төрийн албан хаагч нийтийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, хүнд сурталгүй, шуурхай, хариуцлагатайгаар төрийн үйлчилгээг үзүүлж буйд хяналт тавьж ажиллана.

4. Төрийн үйлчилгээний талаар гаргасан иргэдийн гомдол, хүсэлтийг хүлээн авч хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээг шат дараатайгаар авч ажиллана. Энэ талаар иргэдэд ил тод нээлттэй мэдээллэнэ.

5. Төрийн байгууллага бүр “Нээлттэй хаалганы өдөр”-ийг хагас жил бүр зохион явуулдаг болгож хэвшүүлнэ. Төрийн байгууллага, албан тушаалтны ажлыг дүгнэхдээ ажлынхаа үр дүнг иргэдэд тайлагнасан байдал, төрийн албаны шударга байдал, ёс зүйн үнэлгээ, иргэд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжид үндэслэн дүгнэнэ.



**Бор-Өндөр сумын Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөр**

6. Сум хөгжүүлэх сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгөнөөс зээл олгох асуудлыг тухайн сумын ИТХ-аас баталсан чиглэлийн дагуу зээл хүсэгчийн төслийг сонгон шалгаруулна.

7. Сумын ИТХ-ын үйл ажиллагааг бүрэн нээлттэй болгоно. Иргэдийн оролцоог ханган сумын ИТХ-ын хуралдаан, Засаг даргын зөвлөлийн хуралд иргэдийн төлөөллийг оролцуулдаг болно.

8. Төрийн байгууллага бүр “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-г баталж, хэрэгжүүлэн ажиллаж буйд хяналт тавьж ажиллана.

**ТАВ. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ**

1. Инженерийн шугам сүлжээ /халаалт хэрэглээний халуун хүйтэн ус, дулааны шугам/-г шинэчлэх ажлыг улс, орон нутгийн төсвөөр барьж байгуулахад орон нутгийн зүгээс шаардагдах боломжит бүх дэмжлэг туслалцааг үзүүлж ажиллана.

2. Бохир усны шугам сүлжээг шинэчлэх ажлыг улс, орон нутгийн төсвөөр барьж байгуулахад орон нутгийн зүгээс шаардагдах боломжит бүх дэмжлэг туслалцааг үзүүлж ажиллана.

3. Уурхайчин 4 дүгээр багийн Геологийн байрт инженерийн шугам сүлжээг өргөтгөх ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлж ажиллана.

4. Цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлыг улс, орон нутгийн төсвөөр барьж байгуулахад орон нутгийн зүгээс шаардагдах боломжит бүх дэмжлэг туслалцааг үзүүлж ажиллана.

5. Сумын төвийг, түүний дотор гэр хорооллыг гэрэлтүүлэг, камержуулах ажлыг үргэлжлүүлж, иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцлийг сайжруулна.


бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

6. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд Хямд үнэтэй орон сууцаар төрийн албан хаагчид болон иргэдийг хангах

7. Онцгой байдлын хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Төрийн банк, Мэдээлэл холбоо ТӨҮГ зэрэг байгууллагуудын барилгыг шинээр барина.

8. Сумын төвийн Цахилгаан дамжуулах агаарын шугамын шинэчлэл хийнэ.

9. Хүүхдийн тоглоомын талбайг сумын төвд шат дараалалтай нэмдүүлнэ.





## Бор-Өндөр сумын Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөр

10. Багийн иргэдийн саналаар эрэмблэгдсэн тухайн жилийн бүтээн байгуулалтын ажлыг ОНХС-ын хөрөнгийн санхүүжилтээр төсөл сонгон шалгаруулах замаар хийж гүйцэтгэнэ.
2. Үйл ажиллагаагаа харилцан дэмжсэн, өртөг шингээсэн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ. Ноос боловсруулах, барилгын түүхий эд материалын үйлдвэр барьж байгуулах санаачлагыг дэмжин ажиллана.
3. Малын гаралтай түүхий эд, дайвар бүтээгдэхүүнийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн болгох үйлдвэр барина.
4. Баялаг бүтээгчдээ бүх талаар дэмжих бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Төрийн болон төсөвт байгууллагыг орон нутгийн баялаг бүтээгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авдаг, тэдэнд үзүүлж буй төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулж, нутгийн захиргааны байгууллага болон арилжааны банк хооронд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах замаар баялаг бүтээгчдээ дэмждэг, хэвлэл мэдээллийн байгууллагаар баялаг бүтээгчдийг үнэгүй сурталчлах боломж бололцоог гаргаж өгөх зэргээр бүхий л боломжоор орон нутгийн баялаг бүтээгчдийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.
5. Нийтийн ахуйн үйлчилгээний төвийг төр хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулж, гар урлал, оёдол засвар болон үйлчилгээний бизнес эрхлэгч иргэдийг ажлын байраар хангана.
6. Малын эрүүл мэндийг хамгаалах, малын ашиг шим, үүлдэр угсааг сайжруулах, мал аж ахуйн түүхий эдийн бэлтгэлийг нэмэгдүүлэх, үнэгүйдлээс хамгаалах зорилгоор мах экспортлох, түүхий эд боловсруулах, бэлчээр ашиглалт, худаг усны хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, малчдын хөдөлмөрийн нөхцөл, амьжиргааг дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
7. Малыг эрүүлжүүлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанаржуулж, мал эмнэлгүүдэд тавих төрийн болон малчдын хяналтыг сайжруулж ажлын тайланг жил бүр багийн ИНХ-д тавиулж байна.
8. Залуу гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон нийгмийн эмзэг зорилтот бүлгийн өрхүүдийг дэмжих зорилгоор “Малжуулах” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
9. Туслах аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг бүх талаар дэмжиж ажиллана. жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, төсөл хөтөлбөр, хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо зэрэг бизнесийг дэмжих байгууллагуудын оролцоотойгоор сум, орон нутгийн онцлог, нөөц бололцоонд тулгуурласан, өвөрмөц шинэ төрлийн өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх төслүүдийг дэмжиж ажиллана.
10. Орон нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулж бай ААНэгж, байгууллагуудтай хамтран ажиллах гэрээнд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах асуудлыг тусган шийдвэрлэнэ.



## Бор-Өндөр сумын Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөр

### ДОЛОО. ГАЗАР НУТАГ, БАЙГАЛЬ ОРЧИН

1. Бор-Өндөр сумыг нутаг дэвсгэртэй болгох асуудлыг аймгийн Засаг дарга, ИТХ, Засгийн газар, УИХ-д шат дараалалтайгаар тавьж, бүрэн шийдвэрлүүлнэ.
2. Бэлчээрийн менежментийн бодлогыг гаргаж хэрэгжүүлнэ. Мэргэжлийн байгууллагын судалгаа дүгнэлтэд үндэслэн бэлчээрийг ашиглах, усжуулах, хамгаалах, сайжруулах төлөвлөгөөг малчид, хөрш сумдын нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
3. Газар зохион байгуулалтыг хот, сумын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулсан байдлаар цэгцэлнэ. Замбараагүй хийгдсэн газар олголтыг цэгцлэх ажлыг үргэлжлүүлнэ.
4. Сумын төвд ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн, ногоон зурвасыг байгуулж, ашиглалт үйлчилгээг “Бор-Өндөр Хот тохижилт” ОНТҮГ-т хариуцуулж эзэнжүүлнэ.
5. Байгалийн нөөцийг үр ашигтай ирээдүйгээ харсан байдлаар ашиглах бодлогыг баримтална. Нэгэнт нээгдсэн, ашиглаж байсан уурхайг бүрэн ашиглах, ашиглалт нь дууссан газруудад нөхөн сэргээлт хийх, гар аргаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааг нөхөрлөлийн хэлбэрт шилжүүлнэ.
6. Шинээр ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл өгөх асуудлыг иргэдийн санал дээр үндэслэн шийдвэр гарган ажиллана.
7. Байгалийн нөөцийн хэрэглээ, ашиглалтыг үр ашигтай болгох, байгальд ээлтэй бохирдол багатай үйлдвэрлэлийг дэмжих, байгальд халтай технологийг хална.
8. Хог хаягдлын менежментийн бодлогыг сумын төвд хэрэгжүүлнэ. Хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах, байгальд ээлтэй байдлаар цэвэрлэх зайлуулах хог хаягдлын менежментийн бодлогыг гаргаж хэрэгжүүлнэ.
9. Багийн иргэдийг улирал бүр нийтийн их цэвэрлэгээнд хамруулж хэвшүүлнэ.
10. Зөвшөөрөлгүй байгалийн чулуу олборлож, ухагдсан газарт нөхөн сэргээлт хийх ажлыг зохион байгуулна.

2317144297  
 IOA0048 90740

### НАЙМ. СОЁЛ УРЛАГ, СПОРТ

1. Хүүхэд залуучууд, олон нийтэд урлаг соёлын боловсрол олгох талаар хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн хүрээнд үндэстэн, ястны онцлог урлагийн өв соёлыг олон нийтэд таниулах, орон нутгийн онцлогтой урлагийн үзүүлбэр үйлчилгээг бий болгох, хүүхэд, залуучуудын урлагийн авъяасыг нээн илрүүлэх, тэднийг урлагт татан оролцуулах, соёлын төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.



## Бор-Өндөр сумын Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөр

2. Орон нутагт ажиллах телевиз, радио, тогтмол хэвлэл, сайтуудыг дэмжин тэдний үйл ажиллагааны тодорхой хэсгийг орон нутгийг сурталчлан таниулахад чиглүүлнэ.

3. Орон нутгийн бүтээлч, авъяаслаг, эрдэм чадалтай ах эгч нараараа бахархах үзлийг өсвөр залуу үеийнхэнд төлөвшүүлднэ. Бага, дунд боловсролын цөм хөтөлбөрийн хичээлээс гадуурх үйл ажиллагаа, амьдрах чадварт суралцах үйл ажиллагааны хүрээнд ЕБС-ийн сурагчдад орон нутгийн боловсрол, соёлын байгууллага, аж ахуйн нэгжүүдээр орж танилцуулах сургалтын хөтөлбөрийг гаргаж, энэхүү үйл ажиллагаанд төр хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулна.

4. Хилийн чанадад, Улаанбаатар хот, бусад аймаг, орон нутагт сурч, ажиллаж, амьдарч байгаа өндөр боловсрол, нарийн мэргэжил эзэмшсэн нутгийн залуус, иргэдийг олж авсан мэдлэг, туршлага, боломжоороо нутгийнхаа нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх асуудалд чиглүүлэн ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэх, тэдгээрийн оновчтой санал, санаачилгыг дэмжих, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нутгийн захиргааны болон төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулна.

5. Үндэсний бөх, сурын харваа болон олимпийн төрлийн спорт, оюуны спортын клуб, секц дугуйланг тогтвортой хичээллүүлэн, улсын цолтой бөхчүүд, харваачид, улс, тив, дэлхий, олимпийн аваргуудыг Бор-Өндөр сумаас төрүүлэхийн төлөө ажиллана.

6. Хэнтий, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр аймгийн хурдан адууны үүлдэр угшлыг хадгалан, сайжруулж улс, бүс, аймгийн уралдаануудад амжилттай сайн уралддаг адууны угсааг Бор-Өндөр суманд бий болгох тал дээр морин спортын холбоо, уяачдын галуудтай хамтран ажиллаж, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжинэ.

7. Үндэсний бөх, буриад сурын харваа, шагайн харвааны дэвжээг байгуулан ажиллуулж, олимпийн төрөлд багтах бөхийн спорт, гар бөмбөг, сагсан бөмбөг зэрэг спортын төрөл, оюуны спорт шатар, даам, ой тогтоолтын клубуудыг байгуулан, нутгийн уугуул иргэд, аймаг орон нутагтаа амьдран суугаа иргэд, олон нийтийн үүсгэл санаачлагыг дэмжиж ажиллана.

8. Бүх нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлнэ. Бүс нутаг, улс, тив, дэлхийн аварга шалгаруулах спортын уралдаан тэмцээнд оролцогчдод дэмжлэг үзүүлэх, спортын клуб, дэвжээг дэмжих, тэдний үйл ажиллагааг сурталчлан таниулах, хувийн хэвшлийн үндэсний спортын төв, чийрэгжүүлэх төв, фитнес клуб байгуулах, ажиллуулах санал санаачлагыг бүх талаар дэмжиж ажиллана.

